# МОНГОЛ УЛСЫН
# БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
# САЙДЫН ТУШААЛ

2002 оны 08 сарын 02 өдөр Дугаар 223 Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2002-2003 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2002 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дашням овогтой Бямбацэрэнг 2002-2003 оны хичээлийн жилээс Канад улсын Саскачеваны Их сургуулийн магистрантурт хөдөө аж ахуйн эдийн засгийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД А.ЦАНЖИД

109

2002 он 08 сар 02 өдөр Бүртгэлийн № 425

. . . УБ . . . аймаг, хот . . . СБД . . . . сум,

дүүргийн нотариатч . . . . . . . . . . би

энэ хуулбарын үнэн зөвийг гэрчлэв.

Үйлчилгээний хөлсөнд . . . 100 . . төгрөг хураав.

Нотариатч . . . . . . . .

0030390